

I-IV/2021


Тархаасан: 5 дугаар сарын 13



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өслөө

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 5.6 хувь, өмнөх оны эцсээс 5.5 хувь, өмнөх сараас 2.4 хувиар өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 12.4 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.6 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 6.3 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 7.6 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 4 дүгээр сард өмнөх оны эцсээс 5.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 12.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 1.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 14.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.8 хувь, тээврийн бүлгийн үнэ 1.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 4 дүгээр сард өмнөх сараас 2.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 4.3 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 10.9 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 12.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2021 оны 4 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2021 IV	2021 IV	2021 IV
		2020 IV	2020 XII	2021 III
Ерөнхий индекс	100.0	105.6	105.5	102.4
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	112.4	112.8	104.3
Согтууруулах ундаа, тамхи	4.4	102.2	101.2	100.2
Хувцас, бөс бараа, гутал	16.6	103.2	100.2	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	106.3	114.9	112.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	105.0	102.2	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	104.3	101.8	100.3
Тээвэр	14.4	99.5	101.0	100.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.3	100.2	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	101.0	100.1	100.0
Боловсролын үйлчилгээ	4.8	100.8	100.4	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	107.6	104.9	100.0
Бусад бараа, үйлчилгээ	5.4	105.4	101.6	100.2

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 4 дүгээр сард 6.0 хувь, 2019 оны 4 дүгээр сард 7.0 хувь, 2020 оны 4 дүгээр сард 4.7 хувь гарч байсан бол 2021 оны 4 дүгээр сард 5.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Инфляцад бараа, үйлчилгээний бүлгүүдийн үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 4 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2018 IV	2019 IV	2020 IV	2021 IV
Ерөнхий индекс	6.0	7.0	4.7	5.6
Хүнсний бараа, ундаа, ус	1.6	2.2	2.1	3.4
Согтууруулах ундаа, тамхи	0.4	0.2	0.2	0.1
Хувцас, бөс бараа, гутал	0.5	1.3	0.9	0.5
Орон сууц, ус, цахилгаан, түлш	1.2	0.9	0.5	0.6
Гэр ахуйн тавилга, бараа	0.3	0.2	0.2	0.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.4	0.4	0.1	0.2
Тээвэр	0.9	0.8	-0.6	-0.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.0	0.0	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.1	0.3	0.3	0.0
Боловсролын үйлчилгээ	0.3	0.3	0.5	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.2	0.2	0.3	0.2
Бусад бараа, үйлчилгээ	0.4	0.2	0.3	0.3

Инфляцын түвшин 2021 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд 5.6 хувь гарсны 3.4 нэгж буюу 60.7 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.


Хүснэгт 3. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 4 дүгээр сард

Үзүүлэлт	2019 IV		2020 IV		2021 IV	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	7.0	100.0	4.7	100.0	5.6	100.0
Импортын барааны нөлөө	2.8	40.0	1.2	25.5	1.7	30.4

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлж байна.


Инфляц 2021 оны 4 дүгээр сард 5.6 хувь гарсны 30.4 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 4.9 пунктээр өссөн байна.

Зураг 2. Хүнс, хүнсний бус бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар



Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2020 оны 4 дүгээр сард 7.4 хувиар, 2021 оны 4 дүгээр сард 11.0 хувиар өсөж, өсөлтийн хурдац 3.6 пунктээр өсөж, хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 4 дүгээр сард 3.5 хувиар өсөж, 2021 оны 4 дүгээр сард 3.0 хувиар өсөж, өсөлтийн хурдац 0.5 пунктээр буурчээ.

Зураг 3. Бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар



Барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2020 оны 4 дүгээр сард 4.3 хувиар, 2021 оны 4 дүгээр сард 6.8 хувиар өсөж, өсөлтийн хурдац 2.5 пунктээр өсөж, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 4 дүгээр сард 6.0 хувиар, 2021 оны 4 дүгээр сард 1.7 хувиар өсөж, өсөлтийн хурдац 4.3 пунктээр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс, бүсээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 4 дүгээр сард

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	Ерөнхий индекс	104.7	105.3	103.7	103.7	104.2	104.8
2020 IV	Бараа	104.3	105.0	102.2	103.6	104.0	104.2
	Үйлчилгээ	106.0	106.0	109.3	104.2	105.4	107.0
	Ерөнхий индекс	105.6	106.0	105.5	104.3	105.2	105.8
2021 IV	Бараа	106.8	107.5	106.8	105.3	106.3	106.7
	Үйлчилгээ	101.7	102.2	100.9	100.5	100.6	102.1


Хэрэглээний үнийн индексийг бараа, үйлчилгээний бүлгээр авч үзэхэд 2021 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотод барааны бүлгийн үнэ 7.5 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ Улаанбаатар хотод 2.2 хувиар өссөн нь хамгийн их байна.

Хүснэгт 5. Хүнс, хүнсний бус бүлгийн үнийн индекс, бүлгээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 4 дүгээр сард

Огноо	Хүнс, хүнсний бус	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	Ерөнхий индекс	104.7	105.3	103.7	103.7	104.2	104.8
2020 IV	Хүнс	107.4	108.3	104.1	106.3	108.0	104.6
	Хүнсний бус	103.5	103.8	103.6	102.7	102.6	104.8
	Ерөнхий индекс	105.6	106.0	105.5	104.3	105.2	105.8
2021 IV	Хүнс	111.0	111.5	111.0	109.7	109.4	113.4
	Хүнсний бус	103.0	103.2	103.4	102.2	103.3	102.6

Хэрэглээний үнийн индексийг хүнс, хүнсний бус бүлгээр авч үзэхэд 2021 оны 4 дүгээр сард Зүүн бүсэд хүнсний бүлгийн үнэ 13.4 хувиар, хүнсний бус бүлгийн үнэ Баруун бүсэд 3.4 хувиар өссөн нь хамгийн их байна.

Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, сараар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2021 оны 4 дүгээр сард өмнөх оны эцсээс 28.6 хувь, өмнөх сараас 10.9 хувиар өслөө. Өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 16.0 хувь, хонины ястай махны үнэ 22.4 хувиар өссөн голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хот:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2021 оны 4 дүгээр сард өмнөх сараас 3.4 хувь, өмнөх оны эцсээс 6.9 хувь, өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өслөө.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 13.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 2.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 4.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 8.4 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 8.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 4 дүгээр сард өмнөх оны эцсээс үеэс 6.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 13.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 1.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 24.7 хувь өссөн нь голлон нөлөөлжээ.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 4 дүгээр сард өмнөх сараас 3.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 4.7 хувь, орон сууц, ус, цахилгаан түлшний бүлгийн үнэ 19.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод 2021 оны 4 дүгээр сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 15.4 хувь буюу 53 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 1.7 хувь буюу 6 бараа, үйлчилгээний үнэ буурч, 82.8 хувь буюу 285 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 43 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг 5. Улаанбаатар хотын хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар




Зураг 6. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2021 оны 4 дүгээр сард 15 919 төгрөгийн үнэтэй байгаа нь 2018 оны 4 дүгээр сараас 58.9 хувь, 2019 оны 4 дүгээр сараас 34.9 хувь, 2020 оны 4 дүгээр сараас 15.7 хувиар, өмнөх оны эцсээс 26.8 хувь буюу 3368 төгрөг, өмнөх сараас 9.2 хувь буюу 1341 төгрөгөөр өссөн байна.

Зураг 7. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2021 оны 4 дүгээр сард 13 853 төгрөгийн үнэтэй байгаа нь 2018 оны 4 дүгээр сараас 65.7 хувь, 2019 оны 4 дүгээр сараас 43.7 хувь, 2020 оны 4 дүгээр сараас 18.0 хувиар өссөн, өмнөх оны эцсээс 23.6 хувь буюу 2 645 төгрөг, өмнөх сараас 9.4 хувь буюу 1187 төгрөгөөр өссөн байна.

Зураг 8. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай махны 1 кг дундаж үнэ 2021 оны 4 дүгээр сард 12 318 төгрөгийн үнэтэй байгаа бөгөөд 2018 оны 4 дүгээр сараас 69.0 хувь, 2019 оны 4 дүгээр сараас 41.4 хувь, 2020 оны 4 дүгээр сараас 25.2 хувиар өссөн, өмнөх оны эцсээс 43.6 хувь буюу 3 739 төгрөг, өмнөх сараас 15.2 хувь буюу 1 626 төгрөгөөр өссөн байна.

Зураг 9. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2021 оны 4 дүгээр сард 1 444 байгаа нь 2018 оны 4 дүгээр сараас 16.5 хувь, 2019 оны 4 дүгээр сараас 19.0 хувь, 2020 оны 4 дүгээр сараас 9.5 хувиар буурсан бол, өмнөх оны эцсээс 0.8 хувь буюу 12 төгрөгөөр өсөж, өмнөх сараас 1 төгрөгөөр буурсан байна.


Аймаг:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс бүх аймагт 3.2-8.0 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 4 дүгээр сард Ховд аймагт 3.2 хувиар өссөн нь хамгийн бага, Баянхонгор аймагт 8.0 хувиар өссөн нь хамгийн их байна.

Зураг 10. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг нийслэлээр, жил бүрийн 4 дүгээр сард (өмнөх оны мөн үеэс)



Зураг 11. Аймагуудад худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ, жил бүрийн 4 дүгээр сард, төгрөгөөр



Аймгуудад 2021 оны 4 дүгээр сард худалдаалагдаж буй хонины ястай 1кг махны дундаж үнэ нь 9972 төгрөг болж, 2020 оны 4 дүгээр сараас дунджаар 1569 төгрөг, 2020 оны 12 дугаар сараас 2447 төгрөгөөр их байна.

Хонины ястай 1кг махны дундаж үнэ 2021 оны 4 дүгээр сард Завхан аймагт 8593 төгрөг байгаа нь хамгийн бага, Хэнтий аймагт 11998 төгрөг байгаа нь хамгийн их байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – тайлант үеийн хувиргасан Ласпейресийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

P_{it}^i – i барааны тайлант үеийн үнэ

P_{io}^i – i барааны суурь үеийн үнэ

Q_{io}^i – i барааны суурь үеийн жин

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан. Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна.

Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.

Эх үүсвэр: ҮСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

Ангилал, код: ХЗХБҮА

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>



Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны ... дугаар сарын ...

Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Д.Батсүх, Т.Жигжидсүрэн
Утас : (976-51)-261561

